



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/331

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн “Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 320 дугаар тогтоол, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.5.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрлийн дагуу Увс аймаг дахь Дэглий цагаан нисэх буудлын ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Батбаатар

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга

Дуудлага худалдаа хөтлөгч:

Б.Гантулга

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Техник үйлчилгээ, засварын хэлтсийн засварын инженер

Нарийн бичгийн дарга:

Г.Чинбат

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Захиргаа, санхүү бүртгэлийн хэлтсийн хууль, эрх зүйн мэргэжилтэн

Гишүүд:

Г.Дэлгэрмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

С.Тамир

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Захиргаа, санхүү бүртгэлийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч

Ц.Цэдэв

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Техник үйлчилгээ, засварын хэлтсийн дарга

1721 01 2066

2.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрлийн дагуу Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал, Дорнод аймаг дахь "Чойбалсан" нисэх буудал, Өмнөговь аймаг дахь "Гурвансайхан" нисэх буудлуудын ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн тээврийн хэрэгслийг тус аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан ажлын хэсэг томилсноор нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэх, ажлын хэсгийн тайлан, баримтыг тус ажлын хэсэгт 2021 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэхийг Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал (Д.Батбаяр), Дорнод аймаг дахь "Чойбалсан" нисэх буудал (М.Энхтөр), Өмнөговь аймаг дахь "Гурвансайхан" нисэх буудал (Ц.Баттулга)-д тус тус даалгасугай.

3. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, нээлттэй дуудлага худалдаанаас олох орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлж, тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ, тайлан, маягын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2021 оны гуравдугаар улиралд багтаан хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга (Б.Батбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ